


## ГУРИЛ, ТЭЖЭЭЛИЙН ҮЙЛДВЭР, ЦЕХ

2019 оны байдлаар Монгол улсад нийт 57 гурил болон тэжээлийн үйлдвэр, цехүүд байгаагаас цагт 2 тн-с дээш тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тэжээлийн үйлдвэр 14 (гурилын үйлдвэр ороод), үлдсэн нь жижиг оврын тэжээлийн цех байна.




### Нийт тэжээл үйлдвэрлэгчдийн тоо (2019 оны байдлаар)

№	Аймаг	Тэжээлийн үйлдвэр, цех		
		Нийт	Ажиллаж байгаа	Үйл ажиллагаа зогссон
1	Архангай	1	1	0
2	Баян-Өлгий	1	1	0
3	Булган	7	7	0
4	Говь-Алтай	1	0	1
5	Дархан-Уул	4	4	0
6	Дорнод	2	2	0
7	Дунд-Говь	1	1	0
8	Орхон	7	2	5
9	Өвөрхангай	14	9	5
10	Сэлэнгэ	3	3	0
11	Төв	4	4	0
12	Увс	5	5	0
13	Хөвсгөл	7	6	1
14	Хэнтий	3	1	2
15	Улаанбаатар	11	11	0
<b>Нийт</b>		<b>71</b>	<b>57</b>	<b>14</b>

### Нийт тэжээлийн үйлдвэрүүд

- Гурилын үйлдвэр
- Малын тэжээлээр дагнасан үйлдвэр





Нийт 57 гурил болон тэжээлийн үйлдвэр, цех байгаа ба эдгээрийн нийлбэр хүчин чадал нь жилд 388,965 тонн, үүний 29,3%-г ашиглаж байна.

*Үйлдвэрүүдийн нийлбэр хүчин чадал*



Үйлдвэрлэгчийн төрөл	Тоо	Бүтээгдэхүүн	Үйлдвэрлэлийн нийлбэр хүчин чадал, тонн/жил	Ашиглаж буй хүчин чадал, хувиар
Гурилын үйлдвэр	27	Хивэг	195,365 тонн	32,0%
Тэжээлийн үйлдвэр, цехүүд	30	Багсармал, хивэг, хорголжин, холмиог тэжээл, уурагт тэжээл	193,600 тонн	26,6%
Нийт	57		388,965 тонн	29.3%

Нийт гурил болон тэжээлийн үйлдвэр, цехүүдийг бүсчлэн авч үзвэл Хангайн бүсэд 25, Төвийн бүсэд 12, Баруун бүсэд 6, Зүүн бүсэд 3, Улаанбаатар хотод 11 байна.

*Төвийн болон Зүүн бүсэд байрлах гурил болон тэжээлийн үйлдвэрүүдийн тоо, аймгаар*




*Баруун, Хангайн бүсэд байрлах гурил болон тэжээлийн үйлдвэрүүдийн тоо, аймгаар*




## ТЭЖЭЭЛЭЭР ДАГНАСАН ҮЙЛДВЭР

Монгол улсын хувьд малын тэжээлээр дагнасан тэжээл үйлдвэрлэдэг нийт 30 аж ахуйн нэгж, цехүүд байна. Үүнээс томоохон 6 аж ахуйн нэгж байгаагаас Улаанбаатар хотод 4, Сэлэнгэ аймагт 1, Дорнод аймагт 1 байна. Нийт тэжээлийн үйлдвэр, цехүүдээс улирлын чанартай 8, байнгын үйл ажиллагаа явуулдаг 22 байна.

Нийт тэжээлийн үйлдвэрүүдээ бүс нутгаар нь аваад үзвэл Хангайн бүс буюу Орхон, Булган, Өвөрхангай зэрэг аймгуудад нийт тэжээлийн үйлдвэрийн 53.3% буюу нийт 16 тэжээлийн үйлдвэр, цехүүд байна.



1995 оноос эхлэн аж ахуйн нэгж, цехүүд малын тэжээлээр дагнасан тэжээлийн үйлдвэрлэлийг эрхэлж эхэлсэн ба 2011 оноос эхлэн тэжээлийн үйлдвэрлэл эрчимтэйгээр нэмэгдэж аж ахуйн нэгжийн тоо 1995 оныхтой харьцуулвал 7 дахин нэмэгдсэн байна.




Зураг 5. Ашиглалтанд орсон тэжээлийн үйлдвэрүүдийн тоо, оноор

Монгол улсын хэмжээнд нийт 30 тэжээлийн үйлдвэр байгаа ба нийлбэр хүчин чадал нь жилд 193.6 мянган тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай байна. Нийт хүчин чадлынхаа 26,6%-д тэжээл үйлдвэрлэж байна.

Бүс нутгуудаар нь аваад үзвэл нийт тэжээл үйлдвэрлэлийн 88.6%-г Улаанбаатар хотод байрлах тэжээлийн үйлдвэрүүд үйлдвэрлэдэг байна.


2018 онд үйлдвэрлэсэн нийт тэжээл хувиар, бүсээр



Нийт тэжээл үйлдвэрлэлийн төрлүүдийг аваад үзвэл манай оронд хамгийн их буюу 56.4% нь багсармал тэжээл үйлдвэрлэдэг байна.


Тэжээлийн үйлдвэрүүд түүхий эдийнхээ 80 орчим хувийг дотоодоос, 20 хувийг импортоор хангаж байна. Үүнээс аж ахуйн нэгжийн 76.6 орчим хувь нь өөрсдөө түүхий эдээ тариалдаг бол үлдсэн 23.4-н хувь нь дотоодоос, зарим нь импортоор түүхий эдээ худалдаж авдаг байна. Импортоор авдаг гол түүхий эд нь эрдэнэ шиш, шар буурцаг, рапс ба шар буурцагийн шахдас, премикс, амин хүчлүүд байна.

Тэжээлийн үйлдвэрүүдийн түүхийн эдийн тариалалт, хувиар



Газар зүйн бүсийн хувьд аваад үзвэл Хангай болон Төвийн бүсийнхэн өөрсдөө түүхий эдээ үйлдвэрлэдэг бол Улаанбаатар хотод байрлах тэжээлийн үйлдвэрүүд түүхий эдээ худалдаж авдаг байна.

Тэжээлийн үйлдвэрүүдийн түүхий эдийн тариалалтын тоо, бүсээр



Нийт аж ахуйн нэгжийн 83.3% нь тэжээлээ хадгалах өөрсдийн агуулахтай ба үлдсэн 16,7% нь одоогоор өөрсдийн тэжээлээ хадгалах агуулахгүй байна.

Тэжээлийн үйлдвэр эрхэлж буй аж ахуйн нэгж, цехүүдийн хувьд 73.3% нь 10 хүртэлх ажилчинтай жижиг тэжээлийн, үйлдвэр, цехүүд байна.

Үйлдвэр, цехүүдийн ажилчдын тоо



Тэжээл үйлдвэрлэхэд тулгамдаж буй асуудлыг судлан үзэхэд нийт судалгаанд хамрагдсан тэжээлийн үйлдвэр, цехүүдийн 61.9% нь хөрөнгө, санхүүгийн хувьд дутмаг үүнээс үүдээд тоног төхөөрөмжөө шинэчлэх боломжгүй байна гэсэн байна. Нэн тэргүүнд шаардлагатай зүйлс бол хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа бөгөөд хөнгөлөлттэй зээлд хамрагдаж тоног төхөөрөмжөө шинэчлэх хүсэлтэй байна.

*Тэжээлийн үйлдвэрүүдэд тулгамдаж буй асуудлууд*

№	Тулгамдаж буй асуудлууд	Хувь
1	Тоног төхөөрөмж шинэчлэх, техникийн хүчин чадлаа нэмэгдүүлэх	26.6%
2	Хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт шаардлагатай	35.3%
3	Борлуулалт тааруу	11.1%
4	Түүхий эд дутмаг	13.3%
5	Бусад	13.7%

Бусад асуудлын хувьд аваад үзвэл зах зээлийн хувьд тогтворгүй, түүхий эдээ тариалах газаргүй, импортын хямд тэжээлүүд ихээр орж ордог зэрэг тулгамдсан асуудлууд тулгардаг байна.

### ГУРИЛЫН ҮЙЛДВЭРҮҮД

Монгол улсын хэмжээнд 2019 оны байдлаар нийт 27 гурилын үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Үүнийг бүс нутгаар нь аваад үзвэл Хангайн бүсэд хамгийн их гурилын үйлдвэрүүд байдаг байна.

